



ТӨВ АЙМАГ  
БҮРЭИ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар A/79

Бүрэн сум

2023 оны нэгдүгээр эээлжийн цэрэг татлага  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь заалт, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.4 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсгийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. 2023 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын ажлыг 04 дүгээр сарын 22-ны өдрийн 09.00 цагт сумын Соёлын төвд зохион байгуулсугай.

2. Уг ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Гишүүд

Б.Отгонхишигт

(Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Д.Мөнхзул

(Эрүүл мэндийн төвийн дарга)

Г.Ундрях-Эрдэнэ

(Соёлын төвийн дарга)

Н.Түвшинжаргал

(Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Л.Цэрэндулам

(Цахим үйлчилгээний ажилтан)

Ц.Лхагва

(Төхөм 1-р багийн Засаг дарга)

З.Пүрэв-Очир

(Баянцогт 2-р багийн Засаг дарга)

Д.Батмөнх

(Монгол 3-р багийн Засаг дарга)

Д.Батмөнх

(Эрдэнэхангай 4-р багийн Засаг дарга)

Б.Оюун-Эрдэнэ

(Өнжүүл 5-р багийн Засаг дарга)

412305132

Т.Мөнхбат  
(Цагдаагийн хэсгийн төлөөлөгч)  
Э.Очирсүх  
(Цагдаа)

Нарийн бичгийн дарга: Б.Болорцэцэг

(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

3.Ажлын хэсгийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг хавсралтаар баталсугай.

4.2023 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагын ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулж, ажил үүргийн хуваарыт заасан чиг үүргээ чанартай гүйцэтгэхийг ажлын хэсгийн ахлагч (Б.Отгонхишигт), гишүүдэд үүрэг болгосугай.

5.Цэрэг татлагатай холбогдуулан 2023 оны 04 дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд сумын нутаг дэвсгэрт Архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглож, худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд мэдээлэл хүргэж, хяналт тавьж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч (Т.Мөнхбат), цагдаа (Э.Очирсүх), Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Н.Түвшинжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Ж.Пүрэв-Очир)-д даалгасугай.



Сумын Засаг даргын 2023 оны 14 дугаар... сарын 14-ний  
өдрийн 14 дугаар захирамжийн хавсралт



### АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮДИЙН АЖИЛ ҮҮРГИЙГ ХУВААРЫН

№	Гүйцэтгэх ажил үүрэг	Хариуцах эзэн	Хугацаа
1.	Гишигийн ажил үүргийг хувваарилан танилцуулж, хэрэгжилтийг хангулна.	ЗДТГ-ын дарга	2023.04.12
2.	Зарлан дуудах хуудас аваад ирээгүй иргэдтэй хуулийн дагуу Захиргааны хариуцлага тооцож, торгуулийн арга хэмжээ авч ажиллан тайлан мэдээг нэгтгэн Цэргийн штабт хүргэнэ.		2023.04.22
3.	Хугацаат цэргийн албанд шинээр татагдсан иргэдийг тээвэрлэх үед эрүүл мэндэд анхаарч, осол зөрчлөөс урьдчилан сэргийлж, аюулгүй ажиллагааны зааварчилгаа танилцуулж ажиллана.		2023.04.30
4.	Шинээр 18 нас хурсэн залуучуудад цэргийг үүрэгтний үнэмлэх нээж олгоно. Цэргийн албанд татагдсан иргэдийн хувийн бичиг баримтын бурдлийг хянаж, зөрчлийг урьдчилан арилгуулна.		2023.04.22
5.	Батлан хамгаалах багц хууль, тогтоомжийг сурталчлах, цэрэг татлагын байранд ирсэн залуучуудад мэдээлэл өгне.		2023.04.21
6.	18-25 насны залуучуудад цэргийн зарлан дуудах мэдэгдэл хуудсыг 10 хоногийн өмнө ар гэрт болон вөрт нь гардуулж өгч гарын үсэг зуруулсан бүртгэл хөтөлж, 2023.04.22-ны өдөр цэрэг татлага явагдах байранд бэлэн байлгана.	Багийн Засаг дарга нар	2023.04.12
7.	Их дээд сургууль, коллежи, MCYT-д сурч байгаа сургачид сургуулийн тодорхойлолт, төлбөр төлсөн баримтын хамт авч ирж заавал өөрийн биеэр цэрэг татлагад оролцуулах зар мэдээллийг хүргэх ажлыг зохион байгуулна.		2023.04.12-2023.04.21
8.	Цэргийн албанд татагдагчийн анкетийг компьютерт шивж, зурагжуулна.		2023.04.18 2023.04.20
9.	Цэрэг татлагын байранд ирж, үзлэгт хамрагдаагүй иргэдийн судалгааг нарийн гаргаж, цагдаагийн байгууллагад шилжүүлнэ.		2023.04.22
10.	Цэргийн албаны тухай хуульд заасны дагуу чөлөөлөгдөх иргэдийн бичиг баримт материалыг үнэ зөв бурдлуулж тодорхойлно.		2023.04.18-2023.04.21
11.	Цэргийн алба хаах нас хэтэрсэн, цэргийн албыг ямар нэгэн хэлбэрээр хаагаагүй 1987-1993, 1994, 1995, 1996, 1997 онуудад төрсөн мөнгөн төлбөрт орсон хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэнд мэдэгдэл хуудас тарааж, цэрэг татлагаар цэрийн штабтай мөнгөн төлбөрийн гэрээ байгуулахаар дуудна.	ЗДТГ-ын дарга, Багийн Засаг дарга нар	2023.04.12 2023.04.20
12.	Шинжилгээ авах бэлтгэл ажлыг хангана.	ЭМТ-ийн дарга	2023.04.21
13.	2023 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагаар эрүүл мэндийн үзлэгт хамрагдан эмчлэгдэх боломжтой хугацаатай үүрэг өгсөн залуучууддаа тодотгол хийж, биеэ эрүүлжүүлэх тал дээр хяналт тавина.		2023.04.22

14.	Цэрэг татлага явуулах байранд ажиллах эмч, сувилагчийг томилон ажиллуулна.		2023.04.22
15.	Цэргийн албандаа татагдсан иргэдийн хувийн бичиг баримтын зөрчлийг урьдчилан арилгуулна.	Нийгмийн бодлогын мэргэжилтэн	2023.04.28 2023.05.01
16.	Цэрэг татлагын хуваарьт өдөр Засаг даргын захирамжаар, архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглож, хяналт тавина.	Цагдаагийн хэсгийн төлөөлөгч Цагдаа Хүнс, ЖДҮ, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн	2023.04.21- 2023.04.22
17.	Цэрэн татлага явагдах тогтоосон хугацаанд ирээгүй иргэдийг баривчлан авчрах ажиллагааг явуулна.	Цагдаагийн хэсгийн төлөөлөгч Цагдаа	2023.04.22
18.	Цэрэг татлагын байрны хэв журмыг сахиулна.		
19.	Цэрэг татлагын байрны ариун цэвэр, халдвартгүйжүүлэлтийг урьдчилан хийж, татлага явуулах байрыг зураглалыг дагуу бэлэн болгож, орох гарах хөдөлгөөнийг зохицуулах зураглал хийнэ.	Соёлын төв	2023.04.21
20.	Цэрэг татлага явагдах хугацааг хууль журам, зар мэдээг цахим хаягаар иргэдэд хүргэж ажиллана.	Цахим үйлчилгээний ажилтан	2023.04.22